Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology, Vol. 3, № 1(287): 87–89 (2007)

ДАЛАН УУЛЫН БИЧЭЭС

Ц.БАТТУЛГА

МУИС-ийн Гадаад хэл соёлын сургууль, Түрэг судлалын төв,
e-mail: ts_battulga@yahoo.com

Түлхүүр үгс: *Руни бичиг, Далан уул*

Өгүүллийн товч агуулга: *Монгол нутгаас, нэн ялангуяа говийн бүс нутгаас олдсон руни бичгийн бага дурсгал болох Далан уулын нэг мөр бичээсийг шинжлэх ухааны эргэлтэд оруулж хэвлэн нийтлүүлсэн нь үгүй ажээ. Иймд бид нэг мөр эл бичээсийг уншиж тайлсан судалгаагаа толилуулж байна.*

1982 онд Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Далан уулнаа археологийн хайгуул судалгаа хийсэн эрдэмтэд руни бичгийн нэг мөр дурсгал олж улмаар урьдчилсан байдлаар уншсанаа тайландаа танилцуулжээ.

Археологич Г.Мэнэс дээрхи тайландаа “Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг “Далан” уулын өмнө биеийн нэгэн салбар жалганаас ганц мөр түрэг бичээсийг оллоо. Уг бичээсийн урт нь 65 см, үсэг зурлагын өндөр нь 6.5 см, өргөн нь 0.9 см. Хадан толгойн дээд хэсэгт наран тал руу харсан нэгэн хавтгай хаданд сийлсэн байна” гээд бичээсийн гар хуулбарыг сийрүүлж “qïpčaq čïno idi qutluγ bol[zun]” хэмээн галиглаад “Кипчакийн чоно онгон нь өлзийтэй буянтай болтугай” хэмээн орчуулсан байна. Тэрбээр бичээсийн төгсгөл дэх “zun” гэсэн гурван үсэг бүхий хэсэг холцрон унасан, “𐰆𐰇𐰋” хэмээх бүтээвэр байж магад гэх үүднээс сэргээн уншсанаа онцлон тэмдэглэжээ (Мэнэс, 1982: 25). Түүнчлэн “Далан уулын зүүн тал, зүүн урд тал, өмнө талд хадны сүг зураг маш их байгаа бөгөөд тэдний зарим нэгийг уг тайланд хавсаргав” (Мэнэс, 1982: 25) гэжээ.

Энэхүү бичээсийн талаар үүнээс өөр судалгаа үгүй бөгөөд бид эл бичгийн дурсгалыг олж судлахаар Далан уулыг зорьсон боловч “ганзага хоосон” буцсан билээ. Археологич Г.Мэнэстэй уулзаж эл бичээсийн тухай асуухад нэгэн бэсрэг бага хаданд руни бичээс байсныг лавтай үзэж хуулснаа хэлсэн билээ. “Далан уул” хэмээх хэдэн зуун гүвээ жалга, аараг адарга толгодоос бүрдэх энэ уулнаас ганц мөр бичээс олно гэдэг бэрх байсан билээ. Эрдэмтэн судлаачид энэхүү бичээсийг олж судлах буй за хэмээн найдна.

Бичээсийн талаарх мэдээ хомс, уншлага судалгаа тодорхой бус байгаа тул тайланд буй гар хуулбарт дулдуйдан дахин нягталсан судалгаагаа толилуулж байна.

Бид өмнө нь хэвлүүлсэн бүтээлдээ “Нэр мэдэгдэж буй ч судлагдаагүй дурсгал” хэмээх зүйлд “Далан уулын бичээс” нэртэйгээр оруулсан болно (Баттулга, 2005: 107). Уул хаднаа руни бичээсээс гадна монгол бичгийн дурсгал мөн байдаг тухай мэдээ бий.

Бичээсийн судалгааг толилуулбал:

Бичээсийн гар хуулбарын сийрүүлгэ:
[(𐰋𐰏)~(𐰃)]𐱅𐰇𐰋𐰚𐰇𐰴𐰇𐰋𐰇𐰃𐰇𐰋𐰇𐰇𐰇𐰇

Үсгийн галиг:
Q ï p č η č N W d i uQ T L G B W l [(η)z N]

Үгийн галиг:
qïpčïη čanu idi qutluγ bol[(uη)~(zun)]

Орчуулга:
Кипичин Чану эзэн өлзийтэй бол[(ог)~(тугай)]

Тайлбар:

Археологич Г.Мэнэс бичээсийн тав дахь үсэг тэмдэгтийг “𐰇(q)” хэмээн үзсэн буй. Түүний гар хуулбараас үзэхэд “𐰇” гэхэд бэрхтэй, харин “𐰃(η)” тэмдэгтийн зартигийг баахан урт татаж бичсэнийг ташаа хуулсан бололтой байна.

Учир нь бичээсийн бусад үсэг тэмдэгт маш гаргацтай тодорхой бичигдсэн атал харин эл үсгийг нилээдгүй өвөрмөц байдлаар бичсэн, нөгөө талаар эхний тэмдэгт болох “𐰇”-аас өөр бичлэгтэй байгаа билээ. Нэг мөрөнд нэг үсгийг хоёр өөр тэмдэгтээр тэмдэглэх боломжгүй юм. Түүнчлэн руни бичгийн дурсгалуудад “Кипчак” гэх овог угсаатны нэр ер дурдагддаггүй билээ.

Кипичин Чану (𐰚𐰋𐰇𐰃𐰇𐰴𐰇 qïpčïη čanu) нь онгод бөө, эзэн тэнгэр эсвээс хүний нэр байж болох юм. Хэрвээ хүний нэр биш гэж үзвэл qïp – сайн билэг, čïη- үүрийн туяа, čanu~čaη- бялхам, дүүрэн гэсэн утгатай үгс болгон задлан үзэж болно. Ийн үзвээс уг бичээсийг “Сайн билэг (ёр)-т үүрийн туяа (мэт) бялхам эзэн (та) өлзийтэй болог” гэж утгачилан буулгаж болох байна.

[(𐰋𐰏)~(𐰃)]𐱅𐰇𐰋 bol[(uη)~(zun)] гэх төгсгөлийн үгийн тухайд 𐱅𐱃𐰇𐰋 boluη (болог), 𐰋𐰏𐱅𐰇𐰋 bolzun (болтугай) хэмээх хоёр үгийн чухам аль нь байсныг бат нуттай хэлэхэд нэн бэрх. Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт орших Арханангийн бичээснээ “𐰃𐱅𐰇𐰋𐰚𐰇𐰇𐰇𐰇

НОМЗҮЙ

Мэнэс Г., 1982 оны археологийн шинжилгээний тайлан, ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан, 1982, т. 25.

Ц.Баттулга, 2005. Монголын руни бичгийн бага дурсгалууд, Тэргүүн дэвтэр, -Corpus Scriptorum, Tom. I, УБ, т. 107.

SUMMARY

Ts. Battulga

RUNIC INSCRIPTION FROM DALAN UUL MOUNTAIN

The inscription from the Mt. Dalan Uul in Nomgon sum, Umno-Govi province was first found by archeologist G.Menes in 1982. The inscription dates to Uighur period.

Origin of the inscription:
[(𐰋𐰚)~(𐰃)]𐰇𐰾𐰋𐰴𐰆𐰓𐰃𐰇𐰋𐰃𐰇𐰋𐰓𐰃

Transliteration:
Q ï p č η č N W d i uQ T L G B W l [(η)z N]

Transcription:
qïpčïη čanu idi qutluγ bol[(uη)~(zun)]

Translation
God bless our Lord Kipichan Chanu